

Эрчим хүчний салбарын тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлага”-ын тухай Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтын танилцуулгыг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. Монгол Улсад уул уурхайн томоохон төслүүд хэрэгжих нь бодитой болж, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг эрчим хүчний дотоодын эх үүсвэрээс хангах зорилгоор “Улаанбаатар ДЦС-5”, “Тавантолгойн ДЦС”, Дорнод бүсийн шинэ эх үүсвэр, Багануур болон нүүрсний бусад уурхайг түшиглэсэн шинэ эх үүсвэр барих асуудлыг 2011 онд багтаан тодорхой болгож, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх,

2. “Монгол Улсын нэгдсэн систем хөтөлбөр”-ийг эрчим хүчний хэрэглээтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, зохих журмын дагуу батлуулан үе шаттайгаар хэрэгжүүлэх.

3. Нийслэл хотыг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор өндөр хүчдэл бүхий цахилгаан дамжуулах сүлжээг (их тойрог буюу кольцо) үүсгэн байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2012 оноос барьж байгуулах.